




германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ГАРЫН АВЛАГА



Улаанбаатар хот
2023 он

Published by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

ХЭВЛЭЛТ

Хэвлэсэн

Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

Хаяг

GIZ Монгол төв оффис

Найман зовхис оффисын байр, Сөүлийн гудамж 21

ШХ 1264, Улаанбаатар 14251

Утас +976 70115340, +976 1131 5340

Цахим хаяг giz-mongolei@giz.de

Цахим хуудас www.giz.de

Төслийн нэр

Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих төсөл (PROGRES)

3-р давхар, 38-р байр, Нэгдсэн үндэстний гудамж

4-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 210646, Монгол улс

Утас +976 7011 7704

Цахим хаяг giz-mongolei@giz.de

Цахим хуудас www.giz.de

Зохиогч/Боловсруулсан

Н. Цолмон

Монголын үйлдвэрлэл эрхлэгчдийн холбооны тэргүүн

Хаяг: СБД 1-р хороо

Цахим хаяг: tsolmon.n@msam.mn

Хянасан

Итгэлийн Мөнхбаяр, GIZ PROGRES, itgel.munkhbayar@giz.de

Агуулгын хариуцлагаас татгалзах тухай

Энэхүү гарын авлагад зохиогчдын зүгээс илэрхийлсэн үзэл бодол болон саналд байгууллагын саналыг тусгаж, илэрхийлээгүй болно. ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) нэрийн өмнөөс /даалгавраар GIZ нь хэрэгжүүлэгч агентлагийн хувьд гарын авлагын агуулгыг хариуцна.

Удиртгал.....	3
Тоног төхөөрөмж сонгох зөвлөмж.....	4-5
Судлагдсан тоног төхөөрөмжүүдийн мэдээлэл.....	6-50
Тэмдэглэл.....	51-52

Энэхүү гарын авлага нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмжийн зөвлөгөө үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд олж авсан мэдлэг, мэдээллийг багцлан нийтэд хүртээлтэй байлгах үүднээс бэлтгэсэн гарын авлага юм.

Зөвлөх үйлчилгээг 2022 оны 5-р сараас 2022 оны 11-р сарын хооронд Ховд, Булган, Орхон аймгуудын жижиг дунд үйлдвэрлэгчдэд үзүүлсэн бөгөөд зөвлөх үйлчилгээний хүрээнд дараах агуулгууд багтсан. Үүнд:


1. Тоног төхөөрөмж худалдан авах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж өгөх
2. Хэрэгцээт тоног төхөөрөмжийн сонголт хийхэд туслах
3. ЖДҮ эрхлэгчдэд хэрэгцээт тоног төхөөрөмжийн мэдээллийг олж өгөх
4. Тоног төхөөрөмж хаанаас хэрхэн худалдаж авах арга замыг зааж өгөх
5. Тоног төхөөрөмж худалдан авахад анхаарах хүчин зүйлсүүдийн мэдээлэл өгөх
6. Тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийснээр бизнест гарах өөрчлөлт, үр ашгийг тодорхойлоход зөвлөх

Тус гарын авлагад оруулсан тоног төхөөрөмж, нийлүүлэгчдийн мэдээлэл нь тухайлсан тоног төхөөрөмж, нийлүүлэгч байгууллагыг дэмжсэн, давуу тал олгосон үйл ажиллагаа биш бөгөөд зах зээл дээрх ЖДҮ эрхлэгчдэд хэрэглэхэд тохиромжтой бүтээгдэхүүнүүдийн мэдээллийг оруулахыг зорьсон болно. Мөн тоног төхөөрөмжийн үнэ болон бусад мэдээлэл тодорхой хугацааны дараа өөрчлөгдөж болох ба тоног төхөөрөмж худалдан авах сонирхолтой ЖДҮ эрхлэгчдийг чиглүүлэх, анхан шатны мэдээллээр хангах зорилготой болно.



Implemented by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Тоног төхөөрөмжид хөрөнгө оруулахад нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагыг тодорхойлох хэрэгтэй. Одоогийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн хүчин чадал дутагддаг бол гарцыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж нь үр ашиг багатай цахилгааны зардал өндөр гардаг, мехнаик ажиллагаа ихтэйн улмаас олон хүн ажиллууладаг бол өндөр үр ашигтай шинэ загварын тоног төхөөрөмж худалдан авч урсгал зардал болон хүнийн нөөцийн зардлыг бууруулах, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нэвтрүүлэх зэрэг зорилгоор тоног төхөөрөмж худалдан авах хэрэгцээ шаардлага үүсч болно.

Зорилгоо тодорхойлсны дараа худалдан авах тоног төхөөрөмжийн хэмжээ, хүчин чадлыг тодорхойлох шаардлагатай. Хэрэгцээ шаардлагыг бизнесийн цар хүрээ, үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн зах зээлийн багтаамж, бодит эрэлт, цаашдын үйлдвэрлэл борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн тодорхойлно. Тухайн бүс нутагт жилд 10,000 ш бүтээгдэхүүн худалдан авах эрэлттэй байхад та жилд 100,000ш бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай тоног төхөөрөмж худалдан авах нь үр ашиггүй хөрөнгө оруулалт болно.

Дараагийн шатанд тоног төхөөрөмжийн сонголтыг хийх ба сонголт хийхдээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Монгол орны хөрс, уур амьсгалын нөхцөлд тохирсон эсэх
- Монгол улсын стандарт, үйлдвэрлэлийн технологийн болон бүтээгдэхүүний чанарын шаардлагад нийцсэн эсэх
- Дагалдах сэлбэг хэрэгсэл олдоцтой эсэх, хэтэрхий өндөр үнэтэй эсэх
- Тоног төхөөрөмж чанартай, эдэлгээ даах чадвартай эсэх
- Үйлдвэрлэгчээс шууд худалдан авч буй эсэх
- Монгол улсад засвар үйлчигээ хийх боломжтой эсэх.

Тоног төхөөрөмж худалдан авах нь хөрөнгө оруулалт ба бизнест хийж буй аливаа хөрөнгө оруулалт нь өгөөжтэй байх хэрэгтэй. Үр ашиггүй хөрөнгө оруулалт хийснээр бизнесийн ашигт ажиллагааг бууруулах, цаашлаад дампууралд хүргэх муу үр дагавар авчирч болох тул тоног төхөөрөмж худалдан авахын өмнө хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолох зайлшгүй шаардлагатай.

Хөрөнгө оруулалтын өгөөжийг тодорхойлохдоо эргэн төлөгдөх хугацаа, хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн хувь, цэвэр өнөөгийн үнэ цэнэ гэх мэт төслийн санхүүжилтын гол, чухал тооцооллуудыг хийж үзэх шаардлагатай.

Хөрөнгө оруулалтын өгөөжийн шинжилгээ хийх жишээ:

Шинжилгээний арга	Хөрөнгө оруулалт	Мөнгөн урсгал					Үр дүн
		2023	2024	2025	2026	2027	
Мөнгөн урсгал	(316.7)	54.8	65.2	76.6	89.2	102.9	72.0
Эргэн төлөгдөх хугацаа							5.2
Өнөөгийн цэвэр үнэ цэнэ	(316.7)	47.6	49.3	50.4	51.0	51.1	(67.2)
Дотоод өгөөжийн хувь	(316.7)	54.8	65.2	76.6	89.2	102.9	7%

Сая.₮

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэдэг үйлдвэрлэгч Цэцэг 316.7 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан. Төсөөллөөр эхний жил 54.8 сая төгрөгийн ашигтай ажиллах ба нийт 5 жилийн турш 388.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар байна. Нийт орж ирэх мөнгөн урсгалаас анхны хөрөнгө оруулалт болох 316.7 сая төгрөгийг хасахад 72.0 сая төгрөгийн ашиг олох ба мөнгөн урсгалын тооцооллоос харахад тоног төхөөрөмж худалдан авах нь ашигтай хөрөнгө оруулалт болохоор байна.

Гэвч мөнгөний үнэ цэнэ инфляцид өртөж буурдаг тул өнөөгийн цэвэр үнэ цэнэ гэх тооцооллийг хийж үзэх шаардлагатай. Инфляци 1 жилд 15% гэж тооцоолж үзэхэд эхний жилийн ашиг 54.8 сая төгрөгөөс 47.6 сая төгрөг болж буурах ба нийт 5 жилийн турш 249.5 сая төгрөгийн ашиг олох тооцоолол гарч байна. Үүнээс тоног төхөөрөмж худалдан авсан дүн болох 316.7 сая төгрөгийг хасахад 67.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллах тооцоололтой байна.


Тус тоног төхөөрөмжийг худалдан авсан мөнгөн дүнг 5 жил 2 сарын дараа нөхөх тооцоололтой байх ба хэрвээ тоног төхөөрөмж 5 жилийн хугацаанд элэгдэж дуусна гэж үзвэл үр ашиггүй хөрөнгө оруулалт болж байна. Мөн дотоод өгөөжийн хувь 7% тай байгаа нь банкны хадгаламжийн хүүнээс бага өгөөжтэй байна.

УХААЛАГ УСАЛГААНЫ СИСТЕМ

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: Terbumtan.com, 86995510

Нийлүүлэх боломжит хугацаа: 7 хоногийн дотор Эрээн хотод ирнэ



Ухаалаг усалгааны иж бүрэн системийн угсралтын бүдүүвчийг харууллаа. Энэ зураг дээр харуулсан усалгааны систем дээр хоёр төрлийн хоолой хэрэглэсэн байгаа нь харагдаж байна. Энэ нь гол шугам болон салаалагч шугам. Гол шугамд 32мм-160мм-ийн диаметр бүхий хоолой ашигладаг бол салаалагч шугамд 20мм-75мм-ийн диаметртэй хоолой ашиглана. Харин микро шугамд 16мм-20мм-ийн диаметртэй хоолой ашиглана. Микро шугам нь ургамал бүрийн үндсэнд усалгаа хийх хамгийн эцсийн нарийн хоолой юм.

1. ГОЛ ШУГАМЫН ХООЛОЙ

Энэхүү хоолойнууд нь усалгааны системийн ус дамжуулах үндсэн шугамд хэрэглэгдэнэ. Та усалгаа хийж буй ургамалынхаа усны хэрэглээ болон зайнаас хамаарч хоолойны диаметрийн сонголтыг хийнэ. Тус хоолойнууд нь усжуулалтын үндсэн гол шугамд хэрэглэгдэнэ. Өөрөөр хэлбэл усан сан болон худгийн насосноос усалгааны талбай руу татах эхний шугам юм. Эндээс салаалагч шугамуудыг холбодог. Салаалагч шугам нь хамгийн ихдээ 100м хүртэл урт байх бөгөөд 16мм, 20мм, 25мм, 32 мм гэсэн диаметртэй байдаг.

Гол шугамын хоолойны үнийн санал/7 хоногийн дотор Эрээн хотод ирнэ:

Диаметр 32мм	Зузаан 0.5мм	Урт 100м	163.71 юань
Диаметр 32мм	Зузаан 1.0мм	Урт 100м	219.40 юань
Диаметр 40мм	Зузаан 0.5мм	Урт 100м	193.00 юань
Диаметр 40мм	Зузаан 1.0мм	Урт 100м	241.36 юань
Диаметр 50мм	Зузаан 0.5мм	Урт 100м	234.85 юань
Диаметр 50мм	Зузаан 1.0мм	Урт 100м	281.35 юань




2. САЛААЛАГЧ ХООЛОЙ

Энэ шугам нь үндсэн гол шугамаас салаалж мөр хооронд татах зориулалтаар хэрэглэгдэнэ. Үндсэн гол шугамын хоолойноос бага диаметртэй байх бөгөөд иэхвчлэн 20мм-75мм-ийн диаметртэй хоолойнуудыг ашиглана.

Салаалагч хоолойны үнийн санал/7 хоногийн дотор Эрээн хотод ирнэ:

Диаметр	20мм	25мм	32мм	40мм	50мм	63мм
Зузаан	2.3мм	2.3мм	3.0мм	3.7мм	3.7мм	4.7мм
Уртын хэмжээ	500м	300м	200м	200м	100м	100м
Даралт даах чадвар	16кг	16кг	16кг	16кг	12.5кг	12.5кг
Материал	Цэвэр PE түүхий эдээр үйлдвэрлэсэн					
Баталгаа	50 жил	50 жил	50 жил	50 жил	50 жил	50 жил
Үнэ	1.48 юань/ метр	1.95 юань/ метр	3.40 юань/ метр	5.30 юань/ метр	6.75 юань/ метр	12.60 юань/ метр



3. МИКРО САЛААЛАГЧ ХООЛОЙ

Салаалагч шугамаас микро салаалагч татна. Энэ нь 3/5мм, 4/7мм, 9/12 мм гэх мэт хэмжээтэй үйлдвэрлэгддэг. Энэ нь дотор болон гадна диаметрийн хэмжээг илэрхийлж байгаа юм. Тухайлбал:3/5мм гэсэн хэмжээ нь дотор диаметр 3мм, гадна диаметр 5мм гэсэн ойлголт билээ. Усалгааны хэмжээнээс шалтгаалан микро салаалагч хоолойг сонгож авдаг. Микро салаалагч нь ургамалыг тэжээгч хамгийн эцсийн хоолой юм. Түүнд хатгуур, шүршүүр, дуслуурыг холбож, усалгааг хийдэг.хоолойнуудыг ашиглана.

Микро салаалагч хоолойны үнийн санал/7 хоногийн дотор Эрээн хотод ирнэ:

Хэмжээ	3/5мм	4/7мм	9/12мм
Нэг боодол	500м	200м	100м
Үнэ:	0.7 юань/метр	0.9 юань/метр	2.7 юань/метр




4. ДУСЛЫН УСАЛГААНЫ ХАТГУУР

Дуслын усалгааны хатгуур нь босоо болон тахир гэсэн хоёр хувилбараар үйлдвэрлэгдэнэ. Энэхүү хатгуурыг усалгаа хийж байгаа ургамалынхаа дэргэд хатгаж, дуслaar усалгаа хийхэд ашиглана. Дуслын усалгааны хатгуурын үнийн санал/7 хоногийн дотор Эрээн хотод ирнэ/:

Хатгуурын багц	Нэг салаа хатгуур	Хоёр салаа хатгуур	Дөрвөн салаа хатгуур
Усалгаа	5-6 литр/цаг	10-12 литр/цаг	20-24 литр/цаг
Хоолой	Нэг ширхэг 3/5 мм	2 ширхэг 3/5 мм	4 ширхэг 3/5 мм
Даралт	1кг - 2.5кг	1кг - 2.5кг	1кг - 2.5кг
Үнэ	Үнэ: 1.3 юань	Үнэ: 2.7 юань	Үнэ: 3.60 юань

А. Дуслын усалгааны хатгуур




1 салаа хатгуурын холболт



2 салаа хатгуурын холболт



4 салаа хатгуурын холболт



ХҮЛЭМЖИЙН УСАЛГААНЫ СИСТЕМ


Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: Terbumtan.com, 86995510


Нийлүүлэх боломжит хугацаа: 7 хоногийн дотор Эрээн хотод ирнэ

Уртын хэмжээ ба шүршигчийн тоо	Нэг салаа таймер	Хоёр салаа таймер
5 метр урт, 5 шүршигч (Англи дэлгэцтэй)	Үгүй	27 доллар
10 метр урт, 10 шүршигч (Англи дэлгэцтэй)	45 доллар	57 доллар
15 метр урт, 15 шүршигч (Англи дэлгэцтэй)	71.2 доллар	80.7 доллар
20 метр урт, 20 шүршигч (Англи дэлгэцтэй)	85.5 доллар	103.5 доллар
25 метр урт, 25 шүршигч (Англи дэлгэцтэй)	108 доллар	121.5 доллар
30 метр урт, 30 шүршигч (Англи дэлгэцтэй)	126 доллар	Үгүй


Үйлдвэрийн баталгаа нэг жил. Үйлдвэрээс Улаанбаатар хүртэл тээврийн зардлыг үйлдвэрлэгч хариуцна.



БОРООЖУУЛАХ САЛАА СИСТЕМИЙН ХОЛБОЛТ



БОРООЖУУЛАХ ХАТГУУРТАЙ СИСТЕМИЙН ХОЛБОЛТ



ТАЙМЕРУУДЫН ХУВИЛБАР



4/7 БОЛОН 8/12 ДУГААРЫН ГУУРС ХОЛБОЖ БОЛНО.



ШҮРШИГЧ ТОЛГОЙНУУД



4 САЛАА ШҮРШИГЧ



ТОМ ШҮРШИГЧ



ЖИЖИГ ШҮРШИГЧ



ЭРГЭЛДЭГЧ ШҮРШИГЧ



ЭРГЭЛДЭГЧ ШҮРШИГЧ



ЭРГЭЛДЭГЧ ШҮРШИГЧ

ХАТГУУРТАЙ ШҮРШИГЧ



ХАТГУУРТАЙ УС ШҮРШИГЧ

УНИВЕРСАЛЬ ХОЛБОГЧ

МӨӨМӨН ТОЛГОЙТ



ГУУРС ХОЛБОХ ЗОРИУЛАЛТТАЙ

РЕЗЬБА ТОЛГОЙТ



ТАЙМЕР ХОЛБОХ ЗОРИУЛАЛТТАЙ

БҮХ ЭД АНГИУД



8/12-ЫН УСЖУУЛАХ СИСТЕМ



4/7-ЫН УСНЫ ГУУРС



8/12-ЫН УСНЫ ГУУРС



ЦАГ ТОХИРУУЛАГЧ ТАЙМЕР



БОРООЖУУЛАГЧ ТОЛГОЙ



ХЭС БОРООЖУУЛАГЧ ТОЛГОЙ



ШҮРШИГЧ ТОЛГОЙ



6 МИНУТАНД ТАЙЛЖ
4 МИНУТАНД УГСРАНА.

ТАЙМЕР.

ЧИЙГИЭЭС ХАМГААЛАГЧ

LCD ДЭЛГЭЦ

ТОВЧЛУУРУУД

БАТАРЕЙ

МӨӨМӨН ХОЛБОГЧ

**УСАЛГАА ХИЙХ
ЦАГИЙГ ТОХИРУУЛНА.**

**ӨДӨРТ 1-16 УДАА
УСАЛГАА ХИЙЖ БОЛНО**

**1 - 59 МИНУТААР
УСАЛГААНЫ
ХУГАЦААГ
ТОХИРУУЛЖ БОЛНО**

УНИВЕРСАЛ ТРАКТОР

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: Terbumtan.com 86995510

Үнэ: 2500 юань

Нийлүүлэх боломжит хугацаа: 5 хоногийн дотор Эрээн хотод ирнэ.

Хөрс хагалах, бутлах, сийрүүлэх, мөрлөх, үрлэх, зэрлэг зулгаах, гялгар уутаар бүтээх зэрэг олон үйлдэлтэй жижиг оврын трактор.

Банкны багтаамж: 3.6 литр бензин

Шатахууны марк: A93

Хөдөлгүүрийн модель: 168FB (Дөрвөн ээлжтэй)

Хөдөлгүүрийн чадал: 6.5 морины хүч

Хөдөлгүүрийн эргэлтийн хурд: 3600 эрг/мин


Хөрсөнд боловсруулалт хийх өргөн: 400мм - 800мм

Хөрсөнд боловсруулалт хийх гүн: 175мм - 300мм

Хүч дамжуулагч: Нейтрал болон давших хөдөлгөөн хийнэ.

Цэвэр жин: 59 кг

Баталгаа: Нэг жил







ХӨРС БУТЛАГЧ ДУГУЙ



ХӨРС СИЙРҮҮЛЭГЧ



ҮРЛЭГЧ АГЕРГАТ






ХӨРС БУТЛАГЧ ДУГУЙ



ХӨРС СИЙРҮҮЛЭГЧ



ҮРЛЭГЧ АГЕРГАТ





ГЯЛГАР УУТААР БҮТЭЭГЧ



ЗЭРЛЭГ УРГАМАЛ ЦӨВӨРЛӨГЧ



ИНДУКЦИЙН МЕТАЛ ХАЙЛУУЛАГЧ

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэх боломжит хугацаа: Эрээн хот хүртэл 7-15 хоног

Нийлүүлэгчийн мэдээлэл: Terbumtan.com 8695510

Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

Тоосонцор үүсгэхгүй, дуу чимээгүй, цацраг туяагүй, ил гал үгүй, утаа бага гэх зэрэг хүрээлэн байгаа орчинд хоргүй төхөөрөмж юм. Уламжлалт хөөрөгтэй зуух болон домен зуухтай харьцуулах юм бол гал түймэрийн аюул багатай бөгөөд овор хэмжээ бага, хөнгөн жинтэй, угсрахад амархан гэх зэрэг орон талаараа давуу юм. Зэс, ган, төмөр, хөнгөн цагаан, алт, мөнгө зэрэг металлуудыг хайлуулан боловсруулахад хэрэглэнэ.

Марк	GP-15	GP-25	GP-35	GP-45
Цахилгаан хэрэглээ	220V	380V	380V	380V
Чадал	15 кВт	25 кВт	30 кВт	40 кВт
Давтамж	30-100 kHz	30-100 kHz	30-100 kHz	30-100 kHz
Хүйтэн усны даралт	0.2 Мра	0.2 Мра	0.2 Мра	0.3 Мра
Үндсэн машинхэмжээ	460*200*385 мм	480*240*400 мм	556*280*470 мм	556*280*470 мм
Нэмэлт машины хэмжээ	Үгүй	Үгүй	360*265*365 мм	360*265*365 мм
Үндсэн машин жин	21 кг	28 кг	25 кг	35 кг
Нэмэлт машины жин	Үгүй	Үгүй	23 кг	30 кг
Усны температур	<40°C	<40°C	<40°C	<40°C
Усны зарцуулалт	450 литр/цаг	450 литр/цаг	450 литр/цаг	450 литр/цаг
Баталгаа	Нэг жил	Нэг жил	Нэг жил	Нэг жил
Үйлдвэрийн үнэ	5800 юань	10000 юань	11800 юань	14500 юань

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ПРОЦЕСС



Вааранд хийнэ.



20 секундний дараа




40 секундний дараа




80 секундний дараа



120 секундний дараа



Хайлш бэлэн




Хэвэнд цутгах



Хэлбэржүүлэх



Эцсийн бүтээгдэхүүн



ХЭВНИЙ СОНГОЛТ



НЭХИЙ ЭЛДЭГЧ

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэх боломжит хугацаа: Эрээн хот хүртэл 7-15 хоног

Нийлүүлэгчийн мэдээлэл: Terbumtan.com 8695510

Үнэ/Эрээн хот хүртэл/: Чийглэг нэхий элдэгч-12,000юань

Хуурай нэхий элдэгч+үртэс сорогч-14,000юань

Хүчдэл: 220вольт

Элдэгчийн өргөн: 183мм

Чадал: 5.5квт

Эргэлтийн хурд: 750-800 эрг/мин

Элдүүр хийх талбай: 0.72*1.3м

Хүчин чадал: 80-110 нэхий/цаг

Хэмжээ: 810*1460*1480мм

Жин: 270кг

Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

Нэхий элдэгч машин нь хоёр төрөл байдаг. Үүнд:

1. Хөнгөн цагаан бултай - хуурай нэхий элдэгч,

2. Чулуун бултай - чийглэг нэхий элдэгч

Хөнгөн цагаан бултай элдэгч машин нь нэхийг уян зөөлөн болгох зориулалттай бол чулуун бултай элдэгч машин нь зузаан нэхийг үрж, нимгэлэх зориулалттай байдаг.





БЛОКНЫ ҮЙЛДВЭР

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэх боломжит хугацаа: Эрээн хот хүртэл 7-15 хоног

Нийлүүлэгчийн мэдээлэл: Terbumtan.com 8695510

Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

Бага, дунд, том оврын 6 төрлийн блокны машинуудын иж бүрэн шугамын мэдээллийг хүснэгтэд тусгав.

Загвар:	2-45	4-35A	4-35B	4-35C	4-35D	4-20
Блок хэвлэгч машины үнэ	6000 юань	8500 юань	9600 юань	12000 юань	12500 юань	49000 юань
Бетон зуурагч 250 марк	3200 юань	3200 юань	3200 юань	3200 юань	3200 юань	3200 юань
Зуурмагын конвейор	Хэрэггүй	1580 юань	1580 юань	1580 юань	1580 юань	1580 юань
Эрээн хот хүртэл тээврийн зардал	800 юань	3000 юань	3200 юань	3800 юань	4000 юань	4500 юань
Нийт үнэ:	10000 юань	16280 юань	17580 юань	20580 юань	21280 юань	58280 юань

1. БЛОК ХЭВЛЭГЧ МАШИНУУД

Хэвний тоо: 240*53*115мм хэмжээтэй стандарт тоосго 6 ширхэгээр, 390*190*190мм хэмжээтэй нүхтэй блокыг нэг ээлжиндээ 2-4 ширхэгээр үйлдвэрлэнэ.

Загвар:	2-45	4-35A	4-35B	4-35C	4-35D	4-20
Цахилгаан хэрэглээ:	220 вольт	380 вольт	380 вольт	380 вольт	380 вольт	380 вольт
Цахилгаан зарцуулалт:	1,1 квт	4,4 квт	4,8 квт	4,8 квт	5,5 квт	21 квт
Нэг удаа хэвлэх блок	2 блок	4 блок	4 блок	4 блок	4 блок	4 блок
Вибраторын чичрэлт:	2800 цохилт/мин	2800 цохилт/мин	2800 цохилт/мин	2800 цохилт/мин	2800 цохилт/мин	4800 цохилт/мин
Хэвлэх хугацаа:	45 секунд	35 секунд	35 секунд	35 секунд	35 секунд	20 секунд
Ашиглах хэлбэр:	Зөөврийн	Суурин	Суурин	Суурин	Суурин	Суурин
Батлагаа:	Нэг жил	Нэг жил	Нэг жил	Нэг жил	Нэг жил	Нэг жил
Хүндийн жин:	160 кг	750 кг	850 кг	2500 кг	1200кг	5000 кг
Хэмжээ:	80*70*120см	115*125*170см	158*110*210см	155*166*246см	155*166*246см	300*196*240см
Блок хэвлэгч машины үнэ	6000 юань	8500 юань	9600 юань	12000 юань	12500 юань	49000 юань



2. КОНВЕР

Энэхүү конвейор нь барилгын материал, үр тариа, уурхайн баяжмал зэргийг зөөвөрлөх зориулалттай.

Хэмжээ	1.5 квт хөдөлгүүртэй конвейор	3 квт хөдөлгүүртэй конвейор
110мм диаметр гол бүхий 2.5 м урт	1260 юань	1340 юань
140мм диаметр гол бүхий 2.5 м урт	1320 юань	1400 юань
150мм диаметр гол бүхий 2.5 м урт	1380 юань	1460 юань
220мм диаметр гол бүхий 2.5 м урт	1500 юань	1580 юань



4. ХЭВНИЙ СОНГОЛТУУД

Захиалагчийн зургийн дагуу өөр хэмжээ бүхий хэв үйлдвэрлэж өгч болно.

Загвар		2-45 загварын хэв	4-35 загварын хэв	4-20 загварын хэв
Нэмэлт хэв	2900 юань	3900 юань	666600 юань	



ХЭРЭЭСНИЙ МАШИН/ЭСГИЙ/

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Загвар: Jingling 60/40G

Нийлүүлэгч: www.terbumtan.com

Нийлүүлэх хугацаа: Эрээн хүртэл 14 хоног

Үнэ: 16,000юань

Хүчдэл: 220вольт

Чадал: 1,800ватт

Эргэлт: 2,800 эргэлт/мин

Оёдлын хатгацын зай: 0.1-12.8мм

Ажлын тавцан: 600*400мм

Хэмжээ: 1600x1500x1450мм

Жин: 150 кг

Нэмэлт тайлбар:

Хээ оёгч компьютер машин нь энгийн оёдлын машинаас маш том ялгаатай. Оёдолчин хээ гарган оёх материал дээрээ оёх оёдлын зургийг компьютер дээр боловсруулна. Дараа нь боловсруулсан хээгээ оёдлын машины санах ойд хуулж, сонгоно. Эцэст нь ажлын тавцан дээрээ материалаа оруулж хээгээ сонгож, хөл педаль дээр гишгэхэд машин автоматаар хээг тааруулан, маш хурдан алдаагүй оёно.

Тойрог, дөрвөлжин, гурвалжин, ромбо, угалзан, үг үсэг, тоо, лого гэх мэт хэлбэрүүдээр оёно.





Тогтвортой систем, Өндөр өртөгтэй гүйцэтгэл, Ухаалаг компьютер хавтан



Электрон
хяналтын хайрцаг
ухаалаг бөгөөд
хүчирхэг

ДАНАО брэндийн
Электро механикийн
цогц хяналтын
компьютер систем



НИЙЛЭГ ХАЛЬСАН ХҮЛЭМЖ

Үйлдвэрлэсэн улс: Монгол

Үнэ: 8x20м-9,847,500, 6x10м – 3,805,000

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

Монгол улсад дагаж мөрдөх MNS-6636-2016 стандартын шаардлага хангасан хавар, зун, намар ашиглагдана.

Хэмжээ:

4x8, 6x10, 6x20, 6x30-100, 8x10, 8x20, 8x30-100 болон нийлмэл оройт хүлэмжүүдийг нийлүүлнэ.

Монгол орны нөхцөлд тохирсон материал, тоног төхөөрөмжийн сонголттой, зах зээлд анх танилцуулагдснаас хойш 15 жилийн хугацаанд бүх хот аймаг сумдад суурьлуулагдан, одоо хүртэл ашиглагдаж байна.



ХҮЛЭМЖИЙН НИЙЛЭГ ХАЛЬС

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Үнэ: 8x20м-3,250,000

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

Тунгалаг цэнхэр өнгөтэй, 0.10, 0.15мм зузаантай, 10, 12м өргөнтэй хүлэмжийн зориулалтын нийлэг хальс юм. Уг нийлэг хальс нь -50-өөс +50 хэмд физик шинж чанараа алддаггүй, маш тунгалаг. Гурван давхараат бүтэцтэй полиэтилен (PE) нийлэг хальс юм. Хамгийн гадна давхарга нарны хэт ягаан туяаны хамгаалалт, дунд давхарга дулаан хадгалах, дотор талын давхарга усан дусал үүсгэхгүй байх гэсэн тус тусын үүрэгтэй.

Ашиглалтын хугацаа: 2-5 жил.



ДУСЛЫН УСАЛГААНЫ ҮНДСЭН ХООЛОЙ

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 1м*50мм- 11,200₮ 1м*40мм- 9,900₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Материал: Полиэтилен материалаар хийгдсэн учир маш хөнгөн, бат бөх чанартай

Хэмжээ: 40мм, 50мм

Хэрэглээ: Барилга, уул уурхайн салбарт ус дамжуулах, ус зайлуулах, хөдөө аж ахуйнд төрөл бүрийн усалгаанд өргөн хэрэглэнэ

Эдэлгээний хугацаа: 60жил

Тэсвэрлэх даралт: 6 сар



ДУСЛЫН УСАЛГААНЫ ХООЛОЙ-ВОТЕРФОЛ

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 200м – 264,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Хүлэмж болон ил талбайд хүнсний ногоо, жимс жимсгэнэ услах зориулалтын хоолой:

Дотоод диаметр: 16.0мм

Ханын зузаан: 0.3мм

Дуслуур хоорондын зай: 10см, 20см, 30см, 40см, 50см

Дуслах усны хэмжээ: 1.1л/цаг

Ажиллуулах даралт: 0.5-1.5кг/см²

Тэсвэрлэх даралт: 4.0кг/см²

Дуслын нүхгүй товчин дуслуур цоолж хийдэг





















ХОЛБОГЧУУД

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 1ш 7,500-30,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

 13 Хаалт	 14 Цахилгаан хаалт	 15 Ү холбогч	
 17 Нүхлэгч	 18 Холбогчийн түлхүүр	 19 Фильтер	
 01 Эмээл	 02 Эрвээхэй хаалт	 03 Булан	 04 Резватай булан
 05 Тройник	 06 Резватай тройник	 07 Үндсэн хоолойн холбогч	 08 Балбэ socket
 09 Тред socket	 10 Фудрик	 11 Фа	 12 Таг

ТОВЧИН ДУСЛУУР

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 190мм- 11,200₮ 40мм- 9,900₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Материал: Хуванцар

Дуслах усны хэмжээ: 2л, 4л, 8л



НАМИРАА ХОЛБОЛТУУД

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 1ш 14,000-25,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн



01 Намираа салаалагч



02 Намираа салаалагч



03 Намираа хос салаалагч



04 Намираа салаалагч



05 Намираа хоолой холбогч



06 Бэхлэгч гадас



07 Намираа хоолойн төгсгөгч таг-гадастай

НАМИРАА ХООЛОЙ

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 100м - 160,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Хүлэмж, төмс, хүнсний ногоо, мод үржүүлэгт өргөн хэрэглэдэг. Үйлдвэрээс суулгасан нүхтэй ба намираа бороо мэт зөөлөн услана.

No	Үзүүлэлт	
1	Загвар	Smile spray hose
2	Материал	Полиэтилен
3	Голчын хэмжээ	38мм
4	Далангийн өргөн	110см
5	Услах өргөн	6м хүртэл
6	Нэг эгнээнд суурилуулах тохиромжтой уртын хэмжээ	80м
7	Ажиллуулах тохиромжтой даралт	0.5кг/см2



ТАЛБАЙН БОРООЖУУЛАГЧ

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 1 иж бүрдэл-5,200,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Иж бүрдэлд бороожуулагч насдка 8 ш, тулгуур бүхий хөл 8ш, түгээх даралтын шланк 96м, сорох шланк 8м, сунгалтын шланк 100м, помп насос 1ш орно. Иж бүрдэл нь зөөвөрлөх замаар 1га услах хүчин чадалтай.

Бороожуулагчийн загвар: HS-73

Бороожуулах диаметр: 25-28м

1 га талбайд 8ш насадка тулгуур хөлний хамт суурилуулна.

Тулгуур хөлний өндрийн хэмжээг тохируулах боломжтой.

Усны хоолойн диаметр 50мм, 96м урт



МИНИ БОРООЖУУЛАГЧ

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 1ш-32,500₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Материал: Полиэтилен

Усны гаргалт: 100л/мин




БОРООЖУУЛАГЧ ТОЛГОЙ

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 25,500-825,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн



01 Бороожуулагч толгой



02 Бороожуулагч толгой



03 Бороожуулагч толгой



04 Бороожуулагч толгой



05 Бороожуулагч толгой



06 Бороожуулагч толгой

МАНАНЖУУЛАГЧ - 4 САЛАА ХОШУУТАЙ

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: иж бүрдэл: 8x20 талбайд-2,100,000₮, 6x10 талбайд - 1,400,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Мананжуулагч нь хүлэмжийн агаарын харьцангуй чийгшлийг нэмэгдүүлж, температурыг бууруулдаг. Дөрвөн салаа бүхий хошуу нь усыг маш нарийн тоосруулах бөгөөд ажиллах болон зогссон үедээ усан дусал үүсгэхгүй.



НЭГ МӨРНИЙ ҮРЛЭГЧ

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 450,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Энэхүү гар үрлэгч нь 1 мөрөөр, үрийн суулгах гүн, үр хоорондын зайгаа тохируулан, төрөл бүрийн хэмжээтэй хүнсний ногоо үрлэдэг үрлүүр юм. Үр хоорондын зай тааруулахдаа үйлдвэрээс өгөгдсөн хүснэгтийн дагуу хөтлөгч болон хөтлөгдөгч араануудын хэмжээ, булнуудыг солих замаар замаар 5см-51см хүртэл тохируулдаг. Үрийн суулгах гүнийг хөрс ярагчийг дээш доош болгож хөдөлгөх замаар 1-5см хооронд тохируулна. Хөрс ярагч хошууны ар талд булагч байрладаг. 9кг жинтэй.



МОЛОТОКТОЙ ХҮРЭ


Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 1,925,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

No	Үзүүлэлт	
1	Загвар	ВН125
2	Хөдөлгүүр	Агаарын хөргөлттэй, 2 шатлалт, 1 цилиндр
3	Багтаамж	52сс
4	Чадал	1.9квт
5	Эргэлт	6.600эрг/мин
6	Түлшний савны багтаамж	1.3л
7	Цохилтын давтамж	700-1.350 удаа/цаг
8	Хамгийн их мушгих хүч	2.5н.м
9	Түлшний зарцуулалт	<0.6л/цаг
10	Жин	17.5кг
11	Иж бүрдэл	Дөрвөлжин хүрээ, хумбан хүрээ, хурц үзүүртэй лоом, хавтгай үзүүртэй лоом



ХӨРС ХАЛААГЧ АППАРАТ

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: Халаагч апрад 159,500₮ Халаагч утас 120м-104,500₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Хөрс халаагч аппарат: Хаврын үрсэлгээ хийхэд хөрс халаах шаардлага зайлшгүй гардаг. 1квт-ын 120м урттай 3ш халаагч утсыг зэрэг ажиллуулах хүчин чадалтай. Температурыг 0-40C хооронд тохируулах боломжтой. ,



АРВАН МӨРНИЙ МОТОРТ ҮРЛЭГЧ

Үйлдвэрлэсэн улс: БНСУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: 11,500,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Энэхүү гар үрлэгч нь 10 мөрөөр, үрийн суулгах гүн, үр хоорондын зайгаа тохируулан, төрөл бүрийн хэмжээтэй хүнсний ногоо үрлэдэг үрлүүр юм. Үр хоорондын зай тааруулахдаа үйлдвэрээс өгөгдсөн хүснэгтийн дагуу хөтлөгч болон хөтлөгдөгч араануудын хэмжээ, булнуудыг солих замаар замаар 5см-51см хүртэл тохируулдаг

Үрийн суулгах гүнийг хөрс ярагчийг дээш доош болгож хөдөлгөх замаар тохируулна. Хөрс ярагч хошууны ар талд булагч байрладаг.

Уг үрлэгч нь үрийг нэг нэгээр суулгадаг нь эдийн засгийн хувьд хэмнэлттэйгээс гадна хүний хөдөлмөрийг хөнгөвчилж, цаг хугацааг хэмнэдэгээрээ давvv талтай.



КУЛЬТВАТОР

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэгч: www.evergreenland.mn 7018-7878

Үнэ: Иж бүрдэл-20,500,000₮

Нийлүүлэх боломжит хугацаа: Монголд бэлэн

Олон үйлдэлт хөдөлгүүрт их бие нь дагалдах төхөөрөмжүүдээ ашиглан хөрсийг хагалах, сийрүүлэх, борнойдох, бутлах, шан татах, өргөн болон зурвас далан гаргах, хөрсийг булж тэгшлэх, өвс хадах, тариа хадах, эрдэнэ шиш хадах, гялгар цаасаар хучих, хор цацах, чиргүүл чирэх гэх мэт ажилбаруудыг хийж гүйцэтгэдэг. Эрэгтэй, эмэгтэй, настай гэх мэт ямарч хүн ажиллуулахад хялбар бөгөөд ажлын бүтээмж өндөртэй.

ЗАГВАР		AMC-900
Их бие	Загвар	GM291L
	Нийт урт (мм)	1,490-1,700
	Нийт өргөн (мм)	680-850
	Нийт өндөр (мм)	820-1,140
	Жин (кг)	152 (роторыг оролцуулан)
Хөдөлгүүр	Загвар	GM291L
	Хэлбэр	Агаарын хөргөлттэй, 4 такт, өндөр цохиолтын хавхлагт, бензин
	Шаталтын хөндийн зай (мм)	80 x 59
	Багтаамж (сс)	296
	Үргэлжилсэн эргэлт кв/ эргэлт.мин	4,8/1,800
	Хамгийн их эргэлт кв/ эргэлт.мин	5,9/1,800
	Жин (кг)	26
	Шатахууны савны багтаамж (л)	6.7
	Шатахууны төрөл	Бензин
	Хэрэглэх тос	SAE 10W-30 эсвэл 20W-40
	Асаалтын систем	Татуургат

Үндсэн авцалдуулах холбооны систем	W-Ременэн
Хяналтын авцалдуулах холбооны систем	Бөмбөлөгөн
Дугуй	4.00~7(2PR)
Тэнхлэгийн зай	300-860 (хоёр талруугаа)
Ажиллах өргөн (мм)	220-1,600
Үндсэн дамжуулагч	Урагшаа 4: Ухрах4
P.T.O эргэлт	Доод 714, Дээд1,350

Дээрх үзүүлэлтүүд нь бүтээгдэхүүний сайжруулалтаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой



АВТОМАТ КОФЕ БОЛОН УНДААНЫ МАШИН

Үйлдвэрлэсэн улс: БНХАУ

Нийлүүлэх улс: БНСУ

Үнэ/тээврийн хөлс ороогүй/: 750,000 Вон

Нийлүүлэх боломжит хугацаа: 14 хоног

Хэмжээ: 300x500x640мм

Хүчдэл: 220вольт

Чадал: 1600ватт

Жин: 25кг

Усны савны багтаамж: 2.7л

Кофены төрөл: Хар кофе, сүүтэй кофе, ус, жүүс, цай



ЦАХИЛГААН ХӨРӨӨ

Үйлдвэрлэсэн улс: ХБНГУ

Загвар: Einhell TC-SS 405E

Нийлүүлэгч: Hermes худалдааны төв

Нийлүүлэх боломжит хугацаа: 1 хоног, Монголд бэлэн

Үнэ: 660,000₮


Хүчдэл: 220вольт

Чадал: 120ватт

Эргэлт: 400-1600 эргэлт/мин, 45°-д 27мм, 90°-д 57мм огтолно.

Жин: 12.7 кг

Хүч: 120W



ЦАХИЛГААН ЗҮЛГҮҮР/ТОЧИЛТОЙ/

Үйлдвэрлэсэн улс: ХБНГУ

Загвар: Einhell TH-US 240

Нийлүүлэгч: Hermes худалдааны төв

Нийлүүлэх боломжит хугацаа: 1 хоног, Монголд бэлэн

Үнэ: 440,000₮

Хүчдэл: 220вольт

Чадал: 240ватт

Эргэлт: 2950 эргэлт/мин

Жин: 7.3 кг



ТОКАРИЙН МАШИН

Үйлдвэрлэсэн улс: ХБНГУ

Загвар: Einhell TC-WW 1000/1

Нийлүүлэгч: Hermes худалдааны төв

Нийлүүлэх боломжит хугацаа: 1 хоног, Монголд бэлэн


Үнэ: 1,320,000₮

Хүчдэл: 220вольт

Чадал: 400ватт

Эргэлт: 890-2600 эргэлт/мин

Жин: 22.8 кг



СУУРЬ ХӨРӨӨ

Үйлдвэрлэсэн улс: ХБНГУ

Загвар: TC-TS 2225 U

Нийлүүлэгч: Hermes худалдааны төв

Нийлүүлэх боломжит хугацаа: 1 хоног, Монголд бэлэн

Үнэ: 1,870,000₮



Хүчдэл: 220вольт

Чадал: 1800ватт

Эргэлт: 4,250 эргэлт/мин, 45°-д 55мм, 90°-д 80мм огтолно

Хөрөөний ир: 254мм х 30мм

Жин: 26.2 кг



ҮРТЭС СОРОГЧ ХОЛБОХ БОЛОМЖТОЙ.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 20 rows of evenly spaced dots across the page.

